

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ЯАМНЫ ИЛ ТОД БАЙДЛЫГ ИЛТГЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ
(2016 оны байдлаар)

Шалгуур үзүүлэлт	Биелэлт	Үнэлгээ
Нэг. Үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал		
<p>1.1. Дараах зүйлсийг байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт ойлгомжтой байдлаар байрлуулан тогтмол шинэчилж байх:</p> <p>- байгууллагын эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл болон тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн;</p>	<p>Яамны үйл ажиллагааны стратеги, бүтэц болон стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэлийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүнг тухай бүр яамны сайтад тавьсан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Яамны өдөр тутмын үйл ажиллагаатай холбоотой 371 шинэ мэдээ • Худалдан авах бараа, ажил, үйлчилгээний 39 урилга, үр дүнгийн тайлан • Яамнаас олгосон аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл, татвар төлөгчийн мэдээлэл, тусгай зөвшөөрлийн гэрчилгээ авсан, сунгасан байгууллагын гэрчилгээний үнэ төлсөн жагсаалт • Хүнс, хөдөө аж ахуйн яамны авилгын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө, төлөвлөгөөний биелэлт • Төсөв, төсвийн гүйцэтгэлийн сар, жилийн тайлан, аудитын дүгнэлт • Яаманд ирүүлсэн өргөдөл, гомдол санал хүсэлтийн улирлын мэдээ • Мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого, ЗГ-ын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгагдсан салбарын зорилтын хэрэгжилт, Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлын тогтоол, Засгийн газрын тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн явцад хагас болон бүтэн жилээр хийгдсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний 12 тайлан • Дотоод аудитын төлөвлөгөө, тайлан, 8 дүгнэлт, зөвлөмж • Салбарт хэрэгжиж буй 5 үндэсний хөтөлбөр, 10 гадаадын төслүүдийн үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүнд бүтэн жилээр хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан • Хүнс, хөдөө аж ахуйн салбарт мөрдөгдөж буй эрх зүйн актууд; • Яамны үйл ажиллагааны сар, жилийн төлөвлөгөө, тайлангууд, “Цаг үеийн мэдээлэл” товхимол <p>Яамны вэбэд оруулсан дээрх мэдээллийг давхардсан тоогоор 7 хоногт 3500 гаруй хэрэглэгч үзэж танилцсан нь салбарын мэдээллийн ил тод байдлыг сайжруулах, хэрэглэгчдийг цаг үеийн шинэ мэдээллээр хангах ажилд ахиц, өөрчлөлт гарч байгааг харуулж байна. Мөн эдгээр мэдээлэл нь яамны дотоод мэдээллийн E-оффис програмд давхар орсон.</p>	100

<p>- албан хаагчийн ёс зүйн дүрэм;</p>	<p>Төрийн албаны зөвлөлийн 2010 оны 129 дүгээр тогтоолын 2.3 дахь заалтыг баримтлан яамны албан хаагчдын саналыг авч “Ёс зүйн хороо байгуулах тухай” Төрийн албаны салбар зөвлөлийн Хүнс, хөдөө аж ахуйн яамны дэргэдэх Салбар зөвлөлийн тогтоолоор 2016 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 01 дугаартай тогтоол гарч ёс зүйн хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн байгууллаа.</p> <p>Хүнс, хөдөө аж ахуйн яамны Ёс зүйн хорооны 2016 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн хуралдаанаар Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газрын мэргэжилтэн Б.Алтанцэцэгтэй холбоотой гомдол, мэдээлэл, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн Б.Даваадулам, мэргэжилтэн Н.Нямдорж нартай холбоотой гомдол, мэдээллийг Ёс зүйн хорооны 2016 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн хуралдаанаар тус тус хэлэлцэж ёс зүйн зөрчлийг шалган тогтоож, гаргасан дүгнэлтийг Салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэж, холбогдох шийдвэрийг гаргалаа.</p> <p>Яамны цахим хуудас www.mofa.mn-ны “Хүний нөөц” буланд Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм, төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн тухай зөвлөмж, хичээл, сургалтын материалыг байрлуулснаар ёс зүйн тухай ойлголт, мэдээлэл авах боломж нөхцөлөөр хангалаа. Мөн Ёс зүйн хорооны хуралдаанаар хэлэлцсэн асуудлын тоймыг байршуулав.</p> <p>Яамны цахим хуудасны “Хүний нөөц” буланд иргэдээс “Төрийн албан хаагчийн ёс зүй, хариуцлагын талаар санал, хүсэлт хүлээн авах” буланг ажиллуулж, байгууллагын 1 давхарт байрлах Авилгын эсрэг үйл ажиллагааг сурталчлах мэдээллийн самбарын дэргэд иргэдийн санал, хүсэлтийг хүлээж авах “Саналын хайрцаг” ажиллуулж байна.</p>	<p>100</p>
<p>- төрийн үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн овог, нэр, албан тушаал, хариуцсан ажил, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарь;</p>	<p>Яамны вэбэд өргөдөл гомдол, санал, хүсэлт хариуцсан мэргэжилтний хаяг, яаманд хандаж цахим хэлбэрээр өргөдөл, гомдол гаргах зөвлөмж, өргөдөл, гомдол, санал хүсэлтийн улирал бүрийн мэдээг байрлуулан иргэдийн санал гомдлыг цахим хэлбэрээр авч байна. Цахим хэлбэрээр авсан санал гомдолд тухай бүр хариу илгээж ажилласан.</p>	<p>100</p>
<p>- төрийн үйлчилгээ авахтай холбоотой материалын жагсаалт;</p>	<p>Яамны вэбэд үйлчилгээ хэсэг оруулан тусгай зөвшөөрөл, салбарын шагнал авахад бүрдүүлэх баримт бичиг, түүний хураамж болон иргэдээс цахим хэлбэрээр өргөдөл, гомдол авах зэрэг мэдээллүүд оруулсан.</p>	<p>100</p>
<p>- байгууллагын үйл ажиллагаанд дагаж мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, заавар.</p>	<p>Яамны үйл ажиллагаанд 76 хууль, УИХ-ын 44 тогтоол, Засгийн газрын 138 тогтоол, Сайдын 38 тушаал мөрдөгдөж байгаагаас 2016 онд Хууль 3, УИХ-ын 3, Засгийн газрын 12 тогтоол, Сайдын 7 тушаал, Төрийн нарийн бичгийн даргын 1 тушаалыг шинээр байгууллагын цахим хуудсанд байрлуулсан байна.</p>	<p>100</p>

<p>1.2. Тухайн байгууллагаас үзүүлж байгаа төрийн үйлчилгээний арга хэлбэрийг боловсронгуй болгох чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байх;</p>	<p>Махны нөөц бүрдүүлэх үнийг тогтворжуулах дэд хөтөлбөрийн хүрээнд 6 компанид 46.2 тэрбум төгрөгийн зээл олгож, 14.5 мян.тн нөөцийн мах бэлтгэж, УБ хотын махны хэрэгцээний 16.2 хувийг бүрдүүлсэн, Засгийн газрын үнэт цаас арилжаалж бүрдүүлсэн хөрөнгөөс 2015 онд сүү боловсруулах 3 үйлдвэрт 8.5, эрчимжсэн мал аж ахуйн 25 төсөлд 18.7, сүү боловсруулах цехийн 16 төсөлд 2.2 тэрбум төгрөгийн зээл олгогдсон, Бодлогын гэрээ байгуулсан зоорь байгуулах 39 аж ахуйн нэгжээс 31 аж ахуйн нэгжид нийт 97,6 тэрбум төгрөгийн зээл олгосноор махны зоорь 14.4, төмс, хүнсний ногооны зоорь 10.0 мян.тн-оор нэмэгдсэн, ХАА-н бирж дээр 2015 оны байдлаар ямааны 9 төрлийн ноолуур, тэмээний ноос 8 төрөл, хонины ноос 6 төрөл, тосны ургамал 2 төрөл, ямааны завод ноос 2 төрөл, тэмээний завод ноос 1 төрөл, хонины завод ноос 1 төрөл, мал 1 төрөл, хүнсний буудай 2 төрлөөр арилжсан талаарх мэдээллийг тухай бүр www.mofa.gov.mn, www.zasag.mn сайтуудад мэдээлсэн.</p> <p>Улаанбуудайн болон ноосны урамшуулалд хамрагдсан малчин, тариаланчдын тоо, буудай, ноосны хэмжээ, санхүүжилтийн талаарх мэдээлийн яамны цахим хуудасны урамшуулал хэсэгт оруулсан.</p>	<p>100</p>
<p>1.3. Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хуулиар хориглоогүй аливаа мэдээллийг иргэдэд үнэ төлбөргүй, хүндрэл чирэгдэлгүй өгөх зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байх;</p>	<p>Мэдээллийг иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудад үнэ төлбөргүй өгч байна. 2016 онд иргэд, байгууллагын хүсэлтийн дагуу 281 хүнд 2212 хуудас баримтын хулбар хувийг баталгаажуулан олгосон ба 166 хүнд 853 хадгаламжийн нэгж ашиглуулсан</p>	<p>100</p>
<p>1.4. Нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан шийдвэрээ тухай бүр Хууль зүй, дотоод хэргийн ямаар хянуулан, улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлж, байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлсэн байх;</p>	<p>Сайдын тушаалаар батлагдсан захиргааны хэм хэмжээ тогтоосон 7 шийдвэрийг тухай бүр Хууль зүйн ямаар хянуулан, улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлж, www.legalinfo.mn болон байгууллагын цахим хуудсанд байрлуулсан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - <i>Импортолох стратегийн хүнсний тоо хэмжээг нэмж тогтоох тухай /А-81, 2016-05-30 /</i> - <i>Аргачлал батлах тухай /Хүнсний буудайг хүлээн авах, хадгалалтын үеийн хэвийн хорогдлыг тооцох/ /А-80, 2016-06-24/</i> - <i>Журам батлах тухай /Ургамал хамгаалах биологийн гаралтай бодисыг турших, бүртгэх/ /А-63, 2016-05-02/</i> - <i>Төлөвлөгөө батлах тухай /“Монгол мал” үндэсний хөтөлбөрийн 2 дахь үе шатны буюу 2016-2021 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө/ /А-61, 2016-04-29/</i> - <i>Төлөвлөгөө батлах тухай /Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх эхний үе шат (2016-2020 он)-ны төлөвлөгөө/ /А-60, 2016-04-29 /</i> - <i>Хүнс, хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлэх инновацийн хөтөлбөр батлах тухай /А-43, 2016-03-15/</i> - <i>2016 онд импортолох зарим стратегийн хүнсний тоо хэмжээг тогтоох тухай /А-40 , 2016-03-14/</i> 	<p>100</p>

<p>1.5. Төрийн бодлогын баримт бичиг болон нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг боловсруулахдаа холбогдох төрийн ба төрийн бус байгууллага, мэргэжлийн шинжээч, эрдэмтэн, иргэдийн саналыг авч, үндэслэлтэй гэж үзвэл төсөлд тусгадаг байх;</p>	<p>УИХ-д өргөн барих хуулийн 4, ЗГ-ын тогтоолын 1, сайдын тушаалаар батлагдах захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн 10 төслийг яамны цахим хуудсанд 30 хоног байршуулан нийтээр дагаж мөрдөх шийдвэрийн төсөл боловсруулах журмын дагуу хэлэлцүүлэг зохион байгуулж холбогдох төрийн ба төрийн бус байгууллага, мэргэжлийн шинжээч, эрдэмтэд, иргэдийн саналыг авч, тусган ажилласан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн төсөл - Малын генетик нөөцийн тухай хуулийн төсөл - Бэлчээр хамгаалах тухай хуулийн төсөл - Бэлчээрийн тухай хуулийн төсөл - “Сав, баглаа боодол” үндэсний хөтөлбөр - Монгол Улсад 2017 онд хөдөө аж ахуйд ургамал хамгааллын зориулалтаар ашиглаж болох пестицид, химийн бордооны жагсаалт, хэрэглэх хэмжээний төсөл - “Органик зөгийн аж ахуйд тавигдах шаардлагууд” журмын төсөл - Органик мал аж ахуйн журмын төсөл - Органик газар тариалангийн журмын төсөл - Малын эмийн улсын бүртгэлийн дүрмийн төсөл - Пестицид, ургамлын гаралтай химийн нэгдлүүд, химийн бордоо, ахуйн хортон шавьж, мэрэгч устгалын болон ариутгал, халдваргүйтгэлийн бодисыг турших, ашиглах журмын төсөл - Малын эмийн салбар зөвлөлийн ажиллах журмын төсөл - Хүнсний буудайг хүлээн авах, хадгалах үеийн хэвийн хорогдлыг тооцох аргачлалын төсөл - Хүнс, хөдөө аж ахуйн салбарын шинжлэх ухаан, технологи, инноваци үндэсний чуулганаас гарах зөвлөмжийн төсөл - Монгол улсад 2016 онд хөдөө аж ахуйд ургамал хамгааллын зориулалтаар ашиглаж болох пестицид, тариалангийн зориулалтаар ашиглаж болох химийн бордоо, мал эмнэлгийн зориулалтаар ашиглаж болох ариутгал, халдваргүйтгэлийн зориулалтаар ашиглаж болох пестицидийн жагсаалтын төсөл 	<p>100</p>
<p>1.6. Санал, хүсэлт, өргөдөл, гомдол, мэдээлэл хүлээн авах утас буюу хайрцаг /дэвтэр/ ажиллуулан, түүний мөрөөр тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байх;</p>	<p>Яамны ТЗУГ-ын газарт өргөдөл гомдол санал хүсэлт хариуцсан бие даасан орон тооны мэргэжилтэн ажилладаг тул иргэд өдөр бүр ирж уулзах, утсаар болон бичгээр санал хүсэлт гомдол, мэдээлэл ирүүлж хэвшсэн. Яамны бэв сайтад ажилтны утас, өргөдөл гомдол шийдвэрлэсэн тухай мэдээг улирал бүрээр оруулж нийтэд мэдээллэдэг.</p>	<p>100</p>

	<p>Салбарын холбогдолтой санал хүсэлт 11-11 төвөөр дамжин бүх аймаг сумдаас ирж байна. 11-11 төвөөр дамжиж ирсэн 199 санал хүсэлт, гомдол, шүүмжлэлд тухай бүр хариу илгээж ажиллалаа. Ихэнх санал хүсэлт гомдлууд малчдын амьдрал хүнд байгаа, ноосны урамшуулал, тариаланчдын зээлийн холбоотой байлаа. Иймд ХХААХҮ-ийн сайдын санаачилгаар “Малчдад туслах сайн санааны аян” зарлан зохион байгуулж, нийт 100 гаруй аж ахуйн нэгж, иргэнээс 200 гаруй сая төгрөгийн мөнгөн болон эд материалын тусламжийг хүлээн авч, зудтай, зудархуу байгаа Онцгой байдлын болон олон улсын байгууллагын тусламж очоогүй 9 аймгийн 23 суманд тусламж үзүүлээд байна. Мөн малчдын ноосны урамшууллыг олгуулахаар санхүүжилтийн асуудлаар Сангийн яаманд удаа дараа асуудал тавьж шийдвэрлүүлэн 2016 онд 92885 малчин, мал бүхий этгээдэд 22,6 тэрбум төгрөгийн ноосны урамшуулал олголоо. Тариаланчдын зээлийн асуудлыг Тариалангийн хөгжлийг дэмжих дунд хугацааны хөтөлбөрийн хүрээнд тариалангийн үйлдвэрлэл эрхэлж байгаа 92 аж ахуйн нэгжид 23,4 тэрбум төгрөгийн зээлийг арилжааны банкаар дамжуулан олгож тариаланчдад дэмжлэг үзүүлсэн.</p>	
<p>1.7. Өргөдөл, гомдлыг хуульд заасан хугацаанд шийдвэрлэж, хариуг өгч хэвшсэн байх.</p>	<p>Өргөдөл гомдлын мэдээ тайланг улирал бүр ЗГХЭГ-т хүргүүлж хэвшсэн. 2016 онд тус яаманд иргэд, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллага, 11-11 төв, яамны цахим хаягаар тус тус ирүүлсэн нийт 419 өргөдлийг хүлээн авч судлан, 96.6 хувьд хариу өгч ажилласан. Нийт ирсэн өргөдлийн 288 буюу 68,7 хувь нь санал хүсэлт, 87 буюу 20,7 хувь нь мэдээлэл авах, 30 буюу 7,1 хувь гомдол, 6 буюу 1,4 хувь нь шүүмжлэл, 8 буюу 1,9 хувь нь талархал байна.</p> <p>Үүнээс хамгийн олон хандсан өргөдөл, гомдол, санал хүсэлтүүд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Малчдын амьдрал хүнд байгаа, малын тэжээлийн үнэ, түүхий эд, махны үнийн талаар, мал эрүүлжүүлэх, тариаланчдын зээлийн талаар 60 санал буюу 14,3 2. Ноос, арьс ширний урамшуулалтай холбоотой санал хүсэлт 58 буюу нийт санал хүсэлтийн 13,8 хувь 3. Дэмжлэг хүссэн, бичил төслийн мөнгө хүссэн 24 буюу санал буюу 5,7 <p>Түүнчлэн 2016 онд яамны ажилтнуудаас 129 өргөдөл ирснийг тухай бүр шийдвэрлэсэн болно.</p>	<p>90</p>
<p>Дэд хэсгийн дүн</p>		<p>99.1</p>

Хоёр. Хүний нөөцийн бодлогын ил тод байдал

2.1. Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журам боловсруулан хэрэгжүүлсэн байх;

Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 126 дугаар тогтоолоор баталсан Салбар зөвлөлийн ажил дүгнэх журам, үзүүлэлтийн дагуу Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, Салбар зөвлөлийн үйл ажиллагааны явц, үр дүнг тайлагнаж, төрийн байгууллагуудын үйл ажиллагааны үр дүнг, төрийн жинхэнэ албан хаагчдын ажлын эцсийн үр дүнд чиглэсэн үүрэг хариуцлага, мэдлэг чадварыг дээшлүүлэх зорилтын хүрээнд ажилласан.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны үйл ажиллагааны стратегийн 2 дугаар зорилтын хүрээнд төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагаар хангах, салбарын хүний нөөцийн бодлогыг төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах, төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллаж байна.

2016 онд хүний нөөцийн чиглэлээр үйл ажиллагааны ил тод байдлыг хангах, ажлын хариуцлагыг дээшлүүлэх мэргэшсэн чадварлаг албан хаагчдыг тогтвортой ажиллуулах, төрийн албан хаагчийг давтан сургах, чадавхыг дээшлүүлэх, ажиллах нөхцөл, нийгмийн баталгаагаар хангах зорилтуудыг дэвшүүлэн ажиллаа.

Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн 107 дугаартай тогтоолоор батлагдсан бүрэлдэхүүнээр Хүнс, хөдөө аж ахуйн яамны Салбар зөвлөл эхний хагас жил, Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 221 дүгээр тогтоолоор батлагдсан бүрэлдэхүүнээр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны дэргэдэх Салбар зөвлөл үйл ажиллагаа явууллаа.

Төрийн албаны зөвлөлөөс Салбар зөвлөлүүдийн 2015 оны үйл ажиллагааг дүгнээд, гаргасан зөвлөмжийг үйл ажиллагаандаа чиглэл болгон, Салбар зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөө, яамнаас албан хаагчдад зориулан зохион байгуулах 2016 оны сургалтын төлөвлөгөө төсөв, “Ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийн хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, төсвийг батлуулж, хэрэгжилтийг зохион байгууллаа.

Төрийн албаны хууль тогтоомж, стандартын хэрэгжилт, Төрийн албаны зөвлөлийн шийдвэр, өгсөн үүрэг чиглэл, Салбар зөвлөлийн чиг үүргийн хэрэгжилтийг үндэслэн Төрийн албаны Салбар зөвлөлүүдийн 2016 оны үйл ажиллагааг Төрийн албаны зөвлөлийн үнэлсэн дүнгээр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны дэргэдэх Салбар зөвлөлийн үйл ажиллагаа 12 яамнаас 2 дугаарт орсон байна.

Хүний нөөцийн асуудлаар 2016 онд Сайдын тушаал - 21, Төрийн нарийн бичгийн даргын тушаал-181 тус тус гарсан байна.

50

	<p>- Салбар зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөө, яамнаас албан хаагчдад зориулан зохион байгуулах 2016 оны сургалтын төлөвлөгөө төсөв, “Ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийн хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, төсвийг батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулсан. Салбар зөвлөлийн 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд нийт 5 зорилтын хүрээнд 49 арга хэмжээ, ажил үйлчилгээ гүйцэтгэхээр тусгасан. Төлөвлөсөн арга хэмжээний 49 арга хэмжээг зохион байгуулж ажиллаа. Төлөвлөсөн арга хэмжээний 49 арга хэмжээ бүрэн биелсэн. Төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөрийг 2013 оны 06 сарын 17-ны өдрийн А/82 дугаартай Сайдын тушаалаар баталсан бөгөөд яамны төрийн албан хаагчдын дунд сургалтын хэрэгцээний талаарх судалгааг явуулж 2016 оны сургалтын төлөвлөгөөг гарган ажилласан.</p> <p>Төлөвлөгөөний дагуу зохион байгуулсан сургалт, семинарууд: Төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөрийг 2013 оны 06 сарын 17-ны өдрийн А/82 дугаартай Сайдын тушаалаар баталсан бөгөөд яамны төрийн албан хаагчдын дунд сургалтын хэрэгцээний талаарх судалгааг явуулж, Хүнс, хөдөө аж ахуйн яамны 2016 онд зохион байгуулах сургалтын төлөвлөгөөг Төрийн нарийн бичгийн даргаар батлуулав. Сургалтын төлөвлөгөөнд богино хугацааны 16 сургалт, дунд хугацааны 1 сургалт, урт хугацааны 3 сургалт зохион байгуулахаар тусгасан.</p> <p>Төлөвлөгөөний дагуу дараах сургалт, семинарыг зохион байгуулаад байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Худалдан авах ажиллагааны сургалтыг 2016 оны 01, 11 дүгээр сард; - Хууль зүйн мэдлэг чадварыг дээшлүүлэх сургалтын хүрээнд “Захиргааны ерөнхий хуулийн танилцуулга” сургалтыг 2016 оны 03, 11 дүгээр сард; - Авилгын эсрэг хууль тогтоомж, дүрмийг таниулан сургалчлах, сургалтыг 2016 оны 01, 05 дугаар сард тус тус зохион байгуулсан. Нийт 6 удаагийн сургалт зохион байгуулж давхардсан тоогоор 313 хүн хамрагдаж, төсвөөс 2 250 000 мянган төгрөгийн зардал гаргасан. - Удирдлагын академийн “Төрийн захиргааны менежмент” мэргэжлээр магистрын зэрэг олгох гарагийн тэтгэлэгт сургалтад тус яамны Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргааны дарга О.Амгаланбаатар нэр дэвшин тэнцэж, суралцаж байна. - Архивын ерөнхий газраас зохион байгуулсан “Архив, албан хэрэг хөтлөлтийн онол арга зүй” сэдэвт сургалтад 1 албан хаагч, Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институтээс зохион байгуулсан “Мэргэшсэн нягтлан бодогчийн эрх олгох” сургалтад 1 албан хаагч, Компанийн засаглал төвөөс зохион байгуулсан “Компанийн засаглалын гэрчилгээ олгох” сургалтад 1 албан хаагч хамрагдсан. - БНСУ-ын КОЙКА олон улсын байгууллагын тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд 	
--	---	--

	<p>магистрын сургалтад 1 албан хаагч суралцаж байна.</p> <p>Яамны төрийн албан хаагчдаас гадаадын улс оронд богино хугацааны сургалтад нийт 59 мэргэжилтэн хамрагдаж, Авсртали, Филиппин, Бангладеш, БНФранц Улс, ХНБГУ, Латви Улс Шри-Ланка, Непал, Чех, БНСУ, Голланд БНЧУ, Япон, Вьетнам, БНХАУ, Тайланд, Тайвань Улсын хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн хөгжил, хүнсний аюулгүй байдлын менежмент, таримал ургамлын тариалалт, боловсруулалт, хадгалалт, үйлдвэрлэлийн технологи, малын гаралтай бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөх тогтолцоо, зээлийн батлан даалтын сангийн тогтолцооны талаар туршлага судалсан нь мэргэшлийн чадавхыг дээшлүүлэхэд ихээхэн үр дүнтэй болсон. Гадаад улсад сургалт, семинарт хамрагдсан тухай ажлын тайланг тухай бүр нь авч, бусад албан хаагчдад мэдээлэл түгээх зорилгоор дотоод сүлжээнд илтгэх хуудас байршуулах санг үүсгээд байна.</p> <p>Төрийн нарийн бичгийн даргын 2013 оны А/242 дугаар тушаалаар батлагдсан яамны төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх 5 зорилт, 26 арга хэмжээ бүхий 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг зохион байгуулж ажиллаа. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> - Яамны албан хаагчдын ажилласан жил, зэрэг дэв, цалингийн нэмэгдлийн судалгааг гаргаж 25 төрийн захиргааны албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, 7 албан хаагчид шинээр зэрэг дэв, 7 албан хаагчийн зэрэг дэв түүний нэмэгдлийг ахиулан олголоо. - Эрхэлсэн ажлаа мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэж байгаа яамны эмчид ур чадварын нэмэгдлийг албан тушаалын цалингийн 30 хувиар тооцож олгосон. - Төрийн албан хаагчийн 50, 60 насны ойг тохиолдуулан 4 албан хаагчид дурсгалын зүйл гардуулсан. - Хүүхдийн баярыг тохиолдуулан яамны хурлын танхим болон спорт зааланд албан хаагчдын хүүхдүүдийг хүлээн авч тэдний зурсан зураг, бүтээлээр үзэсгэлэн гаргаж, үлгэрийн баатруудтай хамт зураг авахуулах, хүүхэлдэйн кино үзүүлэх, дуу бүжгийн авъяасыг нь шалгаруулж шагнал гардуулах арга хэмжээг зохион байгуулав. Яамны албан хаагчдын болон үйлчилгээний албан хаагчдын нийт 128 хүүхдэд баярын мэндчилгээ дэвшүүлж бэлэг гардуулсан. - Төрийн нарийн бичгийн даргын 2016 оны Б-48 дугаартай тушаалаар албан хаагчдын ээлжийн амралтын хуваарийг батлав. Албан хаагчдын амралтыг биеэр эдлүүлж, албан ажлын шаардлагаар амралтаа биеэр эдлээгүй 6 албан хаагчид 1.5 сарын албан тушаалын цалинтай тэнцэх мөнгөн урамшил олгов. - ТЗУГ-ын жолооч Б.Жаргалсайханы 60 насны ой, ХШҮДАГ-ын ахлах 	
--	--	--

	<p>мэргэжилтэн Д.Батхуяг, ГТБХЗГ-ын ахлах мэргэжилтэн Г.Эрдэнэцэцэг, ХҮБХЗГ-ын мэргэжилтэн Ц.Цэцэгдарь нарын 50 насны ойг тохиолдуулан тус бүр 50000 төгрөгийн дурсгалын зүйл гардуулав.</p> <ul style="list-style-type: none"> - Шинэ хүүхэдтэй болсон ХШҮДАГ-ын ахлах мэргэжилтэн Д.Батхуяг, ГХАХ-ийн мэргэжилтэн Э.Халиунаа, ТЗУГ-ын бичээч Ц.Байгалмаа, ГХАХ-ийн мэргэжилтэн О.Батхишиг, МААБХЗГ-ын мэргэжилтэн Б.Төгс-Эрдэнэ, Д.Мөнхгэрэл нарт тус бүр 50.000 төгрөгийн мөнгөн тусламж олголоо. - Ар гэрт нь гачигдал гарсан 8 албан хаагчид яамны дотоод журамд заасны дагуу тус бүр 100000.0 төгрөгийн буцалтгүй тусламж олголоо. - Яамны албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Щастины нэрэмжит 3 дугаар эмнэлэгтэй гэрээ байгуулж 1 албан хаагчид 60000.0 төгрөгийн үзлэг, шинжилгээ хийлгэлээ. Нийт 81 албан хаагч хамрагдсан. - Гэрт буюу галладаг сууцанд амьдардаг 12 албан хаагчид өвлийн улиралд түлшний зардалд тус бүр 200000.0 төгрөгийн мөнгөн тусламж олголоо. - Сагс, гар бөмбөг, ширээний теннис, шатрын спортын төрөлд эрэгтэй, эмэгтэй шигшээ баг гаргаж Засгийн газрын цом 2016 тэмцээнд амжилттай оролцож Сагсан бөмбөгийн төрөлд эрэгтэй баг Алтан медаль авлаа. Баг тамирчдыг хоол, унаагаар хангаж, тоглолтын хувцас шинээр хийлгэж дэмжлэг үзүүлэв. Тэмцээнд оролцсон нийт баг тамирчид болох 25 албан хаагчид 3500000.0 төгрөгийн мөнгөн урамшуулал олгосон. - Яамны газар, хэлтсийн хооронд болон яам харьяа байгууллагын хооронд 2 удаа спорт өдөрлөг зохион байгуулж, сагс, гар, бөмбөгийн төрлөөр тус тус аварга шалгаруулж, нийлбэр дүнгээр яамны баг түрүүлж, шилжин явах цом, мөнгөн шагналаар шагнуулав. - Албан хаагчдын нийтийн тээврийн хэрэгслээр ажилдаа ирж очих унааны зардал болон өдрийн хоолны нөхвөрийг 6000 төгрөгөөр тооцон олгож байна. - Албан хаагчдад эрүүл мэндийн байнгын үйлчилгээ үзүүлэх, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор мэргэжлийн эмч ажиллуулж байна. Эхний хагас жилийн байдлаар давхардсан тоогоор 8215 албан хаагчид 16 төрлийн эмнэлгийн анхан шатны үзлэг, үйлчилгээг хийсэн байна. - Иж бүрэн дасгалын хэрэгсэл, төхөөрөмж бүхий чийрэгжүүлэх фитнес танхимыг мэргэжлийн багшаар удирдуулан ажиллуулж албан хаагчид хөнгөлттэй үнээр үйлчлүүлж байна. - Яамны албан хаагчид спорт зааланд долоон хоногийн лхагва, баасан гарагт 17.30-19.30 цагийн хооронд орох хуваарь гаргасан. 	
--	--	--

<p>2.2. Байгууллагын хүний нөөцийн удирдлагын ил тод, нээлттэй байдлыг хангах арга замыг хүний нөөцийн стратегид тусгасан байх;</p>	<p>Төрийн албаны шинэтгэл, төрийн боловсон хүчний бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах, зохицуулахад мэргэшлийн зөвлөгөө, арга зүйн туслалцаа үзүүлэх үүрэг бүхий Төрийн албаны зөвлөлийн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны дэргэдэх Салбар зөвлөл 2016 онд “Салбар зөвлөлийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах, ажлын хариуцлагыг дээшлүүлэх” зорилт дэвшүүлэн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлаж, хэрэгжилтийг ханган ажилласан. “Яамдын зохион байгуулалт бүтэц, орон тооны хязгаар батлах тухай” Засгийн газрын 2016 оны 7 дугаар сарын 27-ны өдрийн 3 дугаар тогтоол, “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын 2016 оны 8 дугаар сарын 14-ний өдрийн 13 дугаар тогтоолоор баталсан бүтэц, орон тооны хязгаарт багтаан, “Зарим яамдын үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр батлах тухай” Засгийн газрын 2016 оны 09 дүгээр сарын 7-ны өдрийн 81 дүгээр тогтоолын 7 дугаар хавсралтаар баталсан “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр”-т тусгасан яамны үйл ажиллагааны стратегийг хэрэгжүүлэн ажиллаж байна.</p> <p>Яамны үйл ажиллагааны стратеги болон бүтцийн өөрчлөлттэй уялдуулан “Тушаалд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2016 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн Б-05 дугаартай тушаалаар яамны бүтцийн нэгжийн орон тоог, “Яамны бүтцийн нэгжийн ажлын байр /албан тушаал/ батлах тухай” Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2016 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн Б-01 дугаартай тушаалаар яамны бүтцийн нэгжийн албан тушаалыг тус тус баталсан. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам дараах бүтцийн нэгжтэй үйл ажиллагаа явуулж байна.</p> <ul style="list-style-type: none"> • Бодлого, төлөвлөлтийн газар, <ul style="list-style-type: none"> - Санхүүгийн хэлтэстэй; • Төрийн захиргааны удирдлагын газар, <ul style="list-style-type: none"> - Гадаад хамтын ажиллагааны хэлтэстэй; - Хуулийн хэлтэстэй; • Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар; • Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар; • Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар; <ul style="list-style-type: none"> - Худалдаа, нийтийн хоол, үйлчилгээний зохицуулалтын хэлтэстэй; • Жижиг, дунд үйлдвэр, хоршооны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар; • Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийн зохицуулах газар; • Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар. 	70
---	--	----

<p>2.3. Хүний нөөцийн стратегийн хэрэгжилтийг үнэлэх, шинэчлэх үйл ажиллагаанд албан хаагчдын оролцох боломжийг бүрдүүлсэн байх;</p>	<p>Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны www.mofa.gov.mn цахим хуудасны “Хүний нөөц” буланд Салбар зөвлөлтэй холбоотой шийдвэр, хууль, дүрэм, журам, 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн асуудалтай холбоотой дүрэм, журам, сургалтын материал, зөвлөмж, гомдол санал хүлээн авах хэсэг, төрийн албан хаагчийн үр дүнгийн гэрээтэй холбоотой мэдээлэл, ажлын байрны сул орон тоо, төрийн жинхэнэ албан тушаалд анх орохтой холбоотой журмыг байршуулан албан хаагч болон иргэдэд мэдээллийг нээлттэй, ил тод түгээж ажиллаа. Хүний нөөцийн асуудлаар гарсан тушаал, шийдвэрийг тухай бүр нь холбогдох албан хаагчдад танилцуулж, яамны дотоод сүлжээ АСУ программаар ажилд томилогдсон болон чөлөөлөгдсөн албан хаагчдын талаар мэдээлж байна. Яамны батлагдсан орон тоонд орсон өөрчлөлтийн мэдээг сар бүр http://www.shilendans.gov.mn цахим хуудсанд байршуулж байна.</p>	<p>70</p>
<p>2.4. Байгууллагын соёл, зохион байгуулалт, үйл ажиллагааны нээлттэй байдлын талаархи сэтгэл ханамжийн судалгааг албан хаагчдаас жил бүр авч, дүнг ил тод танилцуулан, түүний мөрөөр шаардлагатай арга хэмжээ авсан байх;</p>	<p>Нийт албан хаагчдын оролцоотой аппаратын зөвлөгөөний хурлыг зохион байгуулж, албан хаагчдын санал хүсэлт, шүүмжлэлийг хүлээн авч мөрөөр нь зарим арга хэмжээг авч ажиллаж байна. Яамны бүтэц, зохион байгуулалт 2016 оны 07 дугаар сарын 27-ний өдөр өөрчлөгдсөнтэй холбогдуулан “Ажлын хэсэг байгуулах тухай” ТНБД-ын 2016 оны 09 сарын 30-ний А-43 тоот тушаалаар яамны бүтцийн нэгжийн ажлын байр /албан тушаал/ -ны тодорхойлолт боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулж ажиллаа.</p> <p>Ажлын байрны тодорхойлолтыг боловсруулахдаа албан хаагчдаас асуулга авч шинжилгээ хийж, ХХААХҮЯ-ны 98 ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж, Төрийн нарийн бичгийн дарга гарын үсэг зурж баталгаажууллаа.</p> <p>“Журам батлах тухай” Төрийн нарийн бичгийн даргын 2016 оны 11 дүгээр сарын 24-ны өдрийн А-133 дугаартай тушаалаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны хөдөлмөрийн дотоод журам, яамны албан хэрэг хөтлөлтийн журмыг тус тус шинэчлэн батлав. Хөдөлмөрийн дотоод журамд “Албан тушаалд томилох, чөлөөлөх, халах, албан тушаал хавсрах, түр орлон гүйцэтгүүлэх”, “Албан хаагчийн эрх үүрэг”, “Яам, түүний бүтцийн нэгж, албан хаагч ажлаа төлөвлөх, тайлагнах, дүгнэх”, “Төрийн албан хаагчийн ёс зүй”, “Ажлын цагийн горим”, “Шагнал урамшил”, “Төрийн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах” талаар заалт тус бүрээр тодорхой тусгалаа.</p> <p>Яамны албан хаагчдад зориулсан эрх зүйн баримт бичгийн эмхэтгэл хэвлүүлж, ажиллаж байгаа болон шинээр ажилд томилогдсон албан хаагчдад өгч, эмхэтгэлд орсон хууль, дүрэм, журамтай танилцаж, ашиг сонирхлын зөрчил, ёс зүйн зөрчил гаргахаас сэргийлж, хөдөлмөрийн дотоод журам болон албан хэрэг хөтлөлтийн журмыг чанд мөрдөн ажиллах талаар зөвлөн ажиллаж байна.</p>	<p>90</p>

<p>2.5. Сул орон тооны зарыг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр нээлттэй зарласан байх;</p>	<p>Яамны болон харьяа төрийн захиргааны байгууллагын төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалтнууд Төрийн албаны тухай хуулийн 17.1, 17.3, 17.4, 21 дүгээр зүйлд заасны дагуу томилогдон ажиллаж байна.</p> <p>2016 оны байдлаар нийт удирдах албан тушаалын 11 сул орон тоо гарч Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт шийдвэр болон Салбар зөвлөлийн дүгнэлтээр нийт 9 удирдах албан тушаалтныг томилоод байна. Үүнд:</p> <p>Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт, шийдвэрийг үндэслэн яамны бүтцийн нэгж Бодлого, төлөвлөлтийн газрын даргын албан тушаалд М.Энх-Амарыг, Төрийн захиргааны удирдлагын газрын даргын албан тушаалд М.Мөнхбаясгаланг, Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын албан тушаалд Л.Чой-Ишийг, Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын албан тушаалд Ц.Болорчулууныг, Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын албан тушаалд Б.Батхүүг, Жижиг, дунд үйлдвэр, хоршооны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын албан тушаалд М.Дондогдоржийг, Хүнсний үйлдвэрийн хэрэгжилтийг зохицуулах газрын даргын албан тушаалд Т.Гантогтохыг, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын даргын албан тушаалд Д.Совдыг тус тус томилсон.</p> <p>Хуулийн хэлтсийн даргын албан тушаалд томилогдох ажилтанд дүгнэлт гаргах комиссыг 2016 оны 12 дугаар сарын 09-ны өдрийн Салбар зөвлөлийн тогтоолоор байгуулж, сонгон шалгаруулалт хийж Салбар зөвлөлөөс гарсан тогтоолыг үндэслэн Хуулийн хэлтсийн даргын албан тушаалд Б.Батцэцэгийг томилсон.</p> <p>Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд 2016 оны байдлаар нийт Төрийн жинхэнэ албан тушаалын 11 сул орон тоо гарсан байна. Сул орон тооны судалгааг Салбар зөвлөлд тухай бүр танилцуулж ажиллаа.</p> <p>Төрийн жинхэнэ албанд орох иргэний нөөцөөс болон төрийн жинхэнэ албан хаагчийн нөөцөөс 7 албан хаагчийг нэр дэвшүүлэн албан тушаалд томилсон. Үүнд. Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсгийг үндэслэн Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын Санхүү, эдийн засгийн хэлтсийн мэргэжилтний албан тушаалд Г.Мөнхсайхан, Төрийн албаны тухай хуулийн 17.4 дэх заалтыг баримтлан Төрийн албаны зөвлөлөөс ирүүлсэн дүгнэлтийг үндэслэн Төрийн захиргааны удирдлагын газрын мэргэжилтний албан тушаалд Л.Отгонболор, Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн мэргэжилтний албан тушаалд Д.Навчаа, Төрийн нарийн бичгийн даргын туслах бөгөөд Сайд, Төрийн нарийн бичгийн даргын тушаал, шийдвэр, үүргийн биелэлт хариуцсан мэргэжилтний албан тушаалд Ц.Одгэрэл, Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтний албан тушаалд Б.Батбаатар,</p>	<p>100</p>
---	---	------------

	Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтний албан тушаалд Б.Эрдэнэчимэг, Жижиг дунд үйлдвэр, хоршооны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтний албан тушаалд О.Бадамханд, Санхүүгийн хэлтсийн мэргэжилтний албан тушаалд М.Оюунтуяа, Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтний албан тушаалд Я.Батсүх нарыг тус тус томиллоо.	
2.6. Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох чиглэлээр байгууллагын дотоод журамд өөрчлөлт оруулж, хэрэгжилтийг зохион байгуулсан байх.	<p>“Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны хөдөлмөрийн дотоод журам”-ыг шинэчлэн Төрийн нарийн бичгийн даргын 2016 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн А-133 дугаар тушаалаар баталлаа. Журмын 5 дугаар зүйлд яам, түүний бүтцийн нэгж, албан хаагч ажлаа төлөвлөх, тайлагнах талаар тодорхой заалтуудыг тусгасан.</p> <p>“Үр дүнгийн гэрээний загвар, зааварчилга шинэчлэн батлах” тухай Төрийн нарийн бичгийн даргын 2013 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн А/07 дугаар тушаалаар: Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны Төсвийн шууд захирагчийн менежертэй, Менежерийн мэргэжилтэнтэй, Харьяа байгууллагын төсвийн шууд захирагчийн төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулах Үр дүнгийн гэрээ, гэрээний биелэлтийг илтгэх хуудасны загвар, Үр дүнгийн гэрээний биелэлтийг дүгнэх зааврыг Төрийн албаны зөвлөлийн баталсан үлгэрчилсэн загварт нийцүүлэн, байгууллагын онцлогт тохируулан шинэчлэн баталсны дагуу Хүнс, хөдөө аж ахуйн сайд Төрийн нарийн бичгийн даргатай болон харьяа 6 байгууллагын дарга, гүйцэтгэх захиралтай байгуулах үр дүнгийн гэрээ, мөн яамны 76 төрийн албан хаагчийн үр дүнгийн гэрээг 2016 оны 1 дүгээр улиралд багтаан байгууллаа.</p> <p>Яамны албан хаагчдын үр дүнгийн гэрээний биелэлтийн үнэлгээг хагас жилийн байдлаар Салбар зөвлөлийн 2016 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн 02 дугаар хуралдаанаар, бүтэн жилийн байдлаар Салбар зөвлөлийн 2016 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 01 дүгээр хуралдаанаар тус тус хэлэлцүүлж, үнэлгээг баталгаажуулав. Үр дүнгийн гэрээний биелэлтийг дүгнэж өгсөн үнэлгээг үндэслэн “А”, “В” үнэлгээ авсан 73 албан хаагчид мөнгөн урамшуулал олгож, зарим албан хаагчдыг Салбарын шагнал болон Сайдын нэрэмжит шагналаар шагнаж урамшуулав.</p>	100
Дэд хэсгийн дүн		80.0

Гурав. Төсөв, санхүүгийн ил тод байдал		
3.1. Төсвийн төслийг боловсруулахдаа байгууллагын эрхэм зорилго, үйл ажиллагааны зорилт, зорилго, тэргүүлэх чиглэлтэй нягт уялдуулсан байх	Салбарын төсвийн төсөөллийг боловсруулахдаа байгууллагын эрхэм зорилго, үйл ажиллагааны зорилт, зорилго, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн болон 2016 оны салбарын тэргүүлэх зорилтуудтай уялдуулан боловсруулсан. ХХААХҮйлдвэрийн салбарт улсын төсвөөс 201.9 тэрбум төгрөг батлуулан ажилласан.	100
3.2. Үндэсний аюулгүй байдал болон төрийн нууцтай холбоотойгоос бусад байгууллагын тухайн жилийн төсөв, урьд оны төсвийн гүйцэтгэл, дараа оны төсвийн төслийг Монгол Улсын төсвийн ил тод байдал /www.iltod.gov.mn/ цахим хуудсаар болон бусад хэлбэрээр олон нийтэд мэдээлж, мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцлийг бүрдүүлсэн байх	ХХААХҮйлдвэрийн салбарын 2016 оны төсвийн гүйцэтгэл, 2017 оны төсвийг www.shilendans.gov.mn, www.iltod.gov.mn болон яамны цахим хуудасны төсөв, санхүү гэсэн буланд байрлуулсан.	100
3.3. Төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайланг байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж, иргэд иргэний нийгмийн зүгээс төсвийн зарцуулалтад хяналт тавих боломжийг хангасан байна.	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгдсэн байдлын нэгтгэсэн тайланг www.shilendans.gov.mn, www.iltod.gov.mn болон яамны цахим хуудасны төсөв санхүү буланд оруулсан. 2016 оны сар бүрийн төсвийн гүйцэтгэлийг салбар болон яам тус бүрээр оруулсан.	100
3.4. Байгууллагын санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт ойлгомжтой байдлаар байрлуулсан байх	2015 оны жилийн эцсийн салбарын санхүүгийн тайланд Үндэсний аудитын газраас хийсэн санхүүгийн аудитын дүгнэлтийг яамны цахим хуудасны төсөв санхүү буланд оруулсан. ХХААХҮйлдвэрийн салбарын 2016 оны санхүүгийн нэгдсэн тайланд аудитын дүгнэлтийг хуулийн хугацаанд 2016 оны 4 сарын 25-ны дотор ирүүлсэн үед нь цахим хуудсаар мэдээлнэ.	90
3.5. Тухайн жилийн батлагдсан төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулсан тохиолдолд энэ тухай цахим хуудсаар болон бусад хэлбэрээр олон нийтэд мэдээлж, мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцөлөөр хангасан байх	Тухайн жилийн батлагдсан төсөвт оруулсан нэмэлт, өөрчлөлт, төсвийн хуваарийг www.shilendans.gov.mn, www.iltod.gov.mn болон болон яамны цахим хуудсаар олон нийтэд мэдээлсэн.	100
3.6. Зөвхөн хууль тогтоомжид заасан төлбөр, хураамжийг үйлчлүүлэгчээс авч, түүний хэмжээний тухай цахим хуудсаар болон бусад хэлбэрээр олон нийтэд мэдээлсэн байх	ХХАА-н чиглэлийн үйл ажиллагаа эрхлэхэд 14 төрлийн тусгай зөвшөөрөл, үржлийн мал экспортод гаргах лиценз олгох, хугацаа сунгахад бүрдүүлэх бичиг баримт, тэмдэгтийн хураамжийн хэмжээг яамны цахим хуудсанд байрлуулсан. Мал эмнэлгийн эм, эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэх, импортлох, худалдах, малын гүн хөлдөөсөн үр, хөврөл үрийг үйлдвэрлэл, үйчлигэнд нэвтрүүлэх, үржлийн сайжруулагч мал импортлох, экспортлох тусгай зөвшөөрөл олгох, тусгай зөвшөөрлийн хугацаа сунгахад, ургамал хамгаалахад ашиглах бодисыг импортлох,	100

	борлуулах үйл ажиллагаа эрхлэх, таримал ургамлын үр үйлдвэрлэх, согтууруулах ундаа үйлдвэрлэх, хугацаа сунгахад, тамхи үйлдвэрлэх, тамхи үйлдвэрлэх үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах чиглэлээр 2463 тусгай зөвшөөрөл олгох, тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах гэрчилгээний үнэ 1,777,290,0 төгрөгийг Баянзүрх дүүргийн татварын хэлтэст тушааж төсөвт төвлөрүүлэн Улсын тэмдэгтийн хураамжийн тайланг хуулийн хугацаанд хүргүүлсэн.	
3.7. Үйлчилгээний хөлс болон төлбөр, хураамж авах хэлбэрийг боловсронгуй болгох чиглэлээр тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байх	Хүнс, хөдөө аж ахуйн яамнаас 2016 онд олгосон 2463 аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн талаарх мэдээлэл, тусгай зөвшөөрөл авах, хугацаа сунгахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт, тэмдэгтийн үнийн талаарх мэдээллийг яамны цахим хуудасны тусгай зөвшөөрөл хэсэгт байрлуулж, олон нийтэд мэдээлсэн.	100
Дэд хэсгийн дүн		98.6
Дөрөв. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдал		
4.1. Ил тод, шударга, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчимд суурилсан худалдан авах ажиллагааны бодлого баримтлан, байгууллагын дотор мөрдөх журмыг батлан, энэ талаар олон нийтэд мэдээлсэн байх;	Сангийн яамнаас баталсан худалдан авах ажиллагаатай холбоотой журмыг байгууллагад мөрдөж ажилласан. Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2015 оны төсвийн багцад батлагдсан төвлөрсөн арга хэмжээ, хөрөнгө оруулалтын хөрөнгөөр хэрэгжүүлэх "Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлах тухай" Хүнс, хөдөө аж ахуйн сайдын 2016 оны А-164 дүгээр тушаалаар урсгал зардлаар 23 тендер, мал хамгаалах сангийн хөрөнгөөр 4 тендер, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр 9 тендер зарлагдсан. Хүнс, хөдөө аж ахуйн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2016 оны А-18 дугаар тушаалаар Тендерийн үнэлгээний хороодыг байгуулан ажилласан. Монгол Улсын 2016 оны Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар салбарын төсөв буурч батлагдсантай холбогдуулан 9 тендерийн худалдан авах ажиллагааг цуцалж, тендерийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2016 оны А-20 дугаар тушаалаар хүчингүй болгосон.	90
4.2 Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам болон тендерийн урилгыг хуульд заасны дагуу хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлж, цахим хуудас /www.e-procurement.mn/-т байршуулан, тогтмол шинэчилж байх.	Хуулийн дагуу худалдан авах бараа, ажил, үйлчилгээний ерөнхий төлөвлөгөө, тендерийн бичиг баримт, шалгаруулалтыг явуулах журмыг яамны цахим хуудсанд тогтмол байршуулсан. 2016 онд Засгийн газрын худалдан авах ажиллагааны сайтад зарласан 32, яамны сайтад 39 тендер болон бусад арга хэмжээний урилга, үр дүнгийн талаарх мэдээллийг яамны сайтад тухай бүр байрлуулан хэрэглэгчдэд цаг хугацаанд нь хүргэсэн. Тендерийн урилгуудыг давхар өдөр тутмын 2 хэвлэлд нийтэлж байна.	90

4.3 Үнэлгээний хороонд тухайн салбарын 2-оос доошгүй төрийн бус байгууллагын төлөөлөл /ашиг сонирхлын зөрчилгүй болохыг мэдэгдсэн бол/-ийг оролцуулсан байх	Үнэлгээний хороо тус бүрт тухайн салбарын 4 төрийн бус байгууллагын төлөөлөл оролцуулж, тендерийн үнэлгээний хороонд ажилласан төрийн бус байгууллагын тэргүүн гишүүдээс ашиг сонирхлын зөрчилгүй болох тухай мэдэгдлийг 3 удаа бичгээр авч авилгатай тэмцэх газрын цахим хуудсанд байршуулсан.	70
4.4 Тендерт оролцохыг сонирхогчдод тавих шалгуур үзүүлэлт болон гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан үндэслэлийг холбогдох хууль тогтоомжийн дагуу ил тод мэдээлсэн байх	Тендерт оролцохыг сонирхогчдод тавих шалгуур үзүүлэлтийг тендерийн материалд, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан үндэслэл, хасагдсан болон татгалзсан шалтгааныг холбогдох хууль тогтоомжийн дагуу тендерт оролцогчдод өгөх мэдэгдэл тус бүрт оруулж мэдээлсэн.	90
4.5 Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаархи товч мэдээллийг байгууллагын цахим хуудаст байршуулан, шалгарсан болон шалгарч чадаагүй шалтгаан нөхцөл, хуулийн үндэслэлийн талаар тодорхой танилцуулсан байх	Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчдод албан бичгээр тухайн байгууллагуудад шалгарсан болон шалгарч чадаагүй шалтгаан нөхцөл, хуулийн үндэслэлийн талаар танилцуулсан мэдэгдлийг хүргүүлж, мэдээллийг www.e-procurement.mof.gov.mn , www.shilendans.gov.mn болон яамны цахим хуудсанд тухай бүр байршуулсан.	30
4.6 Худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланг тухай бүр байгууллагын цахим хуудаст байршуулж хэвшсэн байх	2016 онд нийт 32 тендер зарлагдахаар төлөвлөгдсөнөөс 32 тендер, урсгал зардлаар 23 тендерээс 23 тендер, Гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр 9 тендерээс 9 тендерийн худалдан авах ажиллагаа зохион байгуулагдсан бөгөөд нийт 43 худалдан авах ажиллагааг хугацаанд нь олон нийтийн хэвлэл мэдээлэл болон www.e-procurement.mof.gov.mn , www.shilendans.gov.mn болон яамны вэбэд нийтэлж маягт 3 дээр санхүүгийн эх үүсвэр, худалдан авах ажиллагааны арга хэмжээ тус бүрээр тайлагнасан. Монгол Улсын 2016 оны Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар салбарын төсөв буурч батлагдастай хобогдуулан 9 тендерийн худалдан авах ажиллагааг зогсоож, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2016 оны А-20 дугаар тушаалаар хүчингүй болгосон.	50
4.7 Тендер шалгаруулах явцад илэрсэн зөрчлийн талаар тухай бүр холбогдох байгууллагад мэдээлсэн байх	Тендер шалгаруулах явцад илэрсэн зөрчлийн талаар тухай бүр холбогдох байгууллагад мэдээлсэн. 2016 онд 2 худалдан авах ажиллагааны үнэлгээнд гаргасан гомдлыг үндэслэлгүй байна гэсэн шийдвэр гарсан.	70
4.8. Худалдан авах ажиллагааны чиглэлээр холбогдох албан хаагчдыг мэргэшүүлсэн байх	2016 онд 2 удаагийн сургалтаар 33 албан хаагчийг худалдан авах ажиллагааны сургалтад хамруулж мэргэшүүлэв. Бусад гишүүдийн сертификатын хүчинтэй хугацаа дуусаагүй байна.	100
4.9 Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт, шалгалтын дүнг байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт байрлуулан, түүнтэй танилцах боломжийг бүрдүүлсэн байх	Жилийн эцсийн санхүүгийн тайланд хийх аудит нь яамнаас зохион байгуулсан худалдан авах ажиллагаанд давхар хийгддэг тул Үндэсний аудитын газраас хийсэн санхүүгийн аудитын дүгнэлтийг тухай бүр яамны цахим хуудсанд байрлуулсан.	90

4.10 Худалдан авах ажиллагаатай холбоотой өргөдөл, гомдлын тоо, тэдгээрийн товч агуулга, шийдвэрлэсэн байдлыг байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт байрлуулан мэдээлсэн байх	2016 онд худалдан авах ажиллагаатай холбоотой өргөдөл, гомдол 3 арга хэмжээнд гарсан бөгөөд 2 худалдан авах ажиллагааны үнэлгээнд гаргасан гомдлыг үндэслэлгүй байна гэсэн шийдвэр гарсан. 1 худалдан авах ажиллагааг зогсоосон.	50
Дэд хэсгийн дүн		73.0
ДУНДАЖ ҮНЭЛГЭЭ		87.7